



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот Чингисийн дүүрэг  
Худалдааны тудамж 6/1 Засгийн газрын 7 байр,  
Утас/Факс: 7976-511 28 75 93 E-mail: fofc@mojna.gov.mn  
<http://www.mojna.gov.mn>

2017.06.08 1-1/2342

танааи № Т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГА Ц.САНДУЙ ТАНАА

Танаас ирүүлсэн Нийслэлийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "Журам  
шинэчлэн батлах тухай" 9/10 дугаар тогтоолыг  
Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж,  
захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн  
бүртгэлийн 3739 дугаарт бүртгэснийг мэдэгдье.



08 1713  
Doc.said a5.2017



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2013. оны 06. сарын 06.-ны  
өдрийн 32 дугаарт бүртгэв.

## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 сарын 27 өдөр


Дугаар 9/10

Улаанбаатар хот

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГООХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журмыг 1 дүгээр, Гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулахыг хориглох гудамж, зам, талбайг 2 дугаар, Нийтийн эзэмшлийн газар, барилга байгууламжид байрлуулах гадна зар сурталчилгааны байгууламжийн төлбөрийг 3 дугаар, Гадна зар сурталчилгаанд тавигдах шаардлагыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Журам батлах тухай" 3/32 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д даалгасугай.



**НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГАА  
БАЙРЛУУЛАХАД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Гадна зар сурталчилгааг нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зорчиж байгаа иргэд, үйлчлүүлэгчдэд зориулан тухайн барилга байгууламжийн архитектур, дизайнтай уялдуулан хотын өнгө үзэмж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасны үндсэн дээр байрлуулж болно.

1.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг мөрдөж ажиллана.

**Хоёр. Гадна зар сурталчилгааны ангилал, төрөл**

2.1. Гадна зар сурталчилгааг доор дурдсанаар ангилна:

- 2.1.1. сурталчилгааны байгууламж;
- 2.1.2. хаягийн байгууламж;
- 2.1.3. зарлалын хуудас.

2.2. Гадна зар сурталчилгааг байрлаж байгаа газар, барилга байгууламж, объектын хувьд доор дурдсанаар ангилна:

- 2.2.1. нийтийн эзэмшил дэх;
- 2.2.2. хувийн эзэмшил дэх.

2.3. Сурталчилгааны байгууламж дараах төрөлтэй байна:

- 2.3.1. дээврийн байгууламж;
- 2.3.2. тулгуурт байгууламж;
- 2.3.3. түр байгууламж;
- 2.3.4. барилга байгууламжийн ханан дахь байгууламж;
- 2.3.5. барилга байгууламжийн хашаа хаалт дээрх байгууламж;
- 2.3.6. гүүрэн байгууламж;
- 2.3.7. нийтийн тээврийн зогсоол дахь байгууламж;
- 2.3.8. загварт байгууламж;
- 2.3.9. хоргот байгууламж;
- 2.3.10. лед гэрлэн байгууламж;

- 2.3.11.нүхэн гарцын байгууламж;
  - 2.3.12 агаарын байгууламж;
  - 2.3.13. хөдөлгөөнт байгууламж.
- 2.4.Хаягийн байгууламж дараах төрөлтэй байна:
- 2.4.1.нэгдсэн хаягийн байгууламж;
  - 2.4.2.гэрэлт хайрцаг;
  - 2.4.3.эзэлхүүнт үсэг бүхий байгууламж;
  - 2.4.4.неон гэрлэн байгууламж;
  - 2.4.5.лед гэрлэн;
  - 2.4.6.хулдаасан, даавуун хэвлэл бүхий;
  - 2.4.7.түг далбаат.

**Гурав. Гадна зар сурталчилгаа байрлуулах  
зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага**

3.1.Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай болон барилга байгууламжид сурталчилгааны байгууламж байрлуулах зөвшөөрлийг доор дурдсан байгууллага олгоно:

- 3.1.1.Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба;
- 3.1.2.Налайх дүүрэгт Налайх хотын Захирагчийн ажлын алба;
- 3.1.3.Багануур дүүрэгт Багануур хотын Захирагчийн ажлын алба;
- 3.1.4.Багахангай дүүрэгт тус дүүргийн Засаг даргын Тамгын газар.

3.2.Хувийн эзэмшлийн барилга байгууламж, объектын хана, дээвэрт байрлуулах сурталчилгааны байгууламж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан шаардлагад нийцсэн байна.

3.3.Хувийн эзэмшил дэх газарт сурталчилгааны байгууламж байрлуулах тохиолдолд сурталчилгааны байгууламжийн өнгө үзэмж, аюулгүй байдлын шаардлагыг тухайн газрыг эзэмшигч хангулж ажиллана.

3.4.Зарлалын хуудсыг зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагын байр, үйлчилгээний газар, орон сууцны хорооллын доторх зориулалтын мэдээллийн самбарт, эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр байрлуулж болно.

**Дөрөв. Гадна зар сурталчилгааг байрлуулах  
зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах**

4.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гадна зар сурталчилгаа байрлуулах хүсэлтээ энэ журмын 3.1-д заасан байгууллагад гаргана. Хүсэлтэд дараах баримтыг хавсаргасан байна:

- 4.1.1.гадна зар сурталчилгаа байрлуулах үндэслэл;
- 4.1.2.гадна зар сурталчилгаа байрлуулах газрын зураг, солбилцлын цэг;
- 4.1.3.байгууламжийн ангилал, төрөл, тоо, хэмжээ, эскиз зураг;

4.1.4. байрлуулах газрын фото монтаж, газрын зураг болон байгууламжийн зургийн эвлүүлэг;

4.1.5. хүсэлт гаргасан этгээд нь аж ахуйн нэгж, байгууллага бол гэрчилгээний хуулбар, тухайн байгууллагын танилцуулга;

4.1.6. хүсэлт гаргасан этгээд нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар.

4.2. Энэ журмын 3.1-д заасан байгууллага гадна зар сурталчилгаа байрлуулах хүсэлтийг хүлээн авч, дараах шаардлагыг хангасан тохиолдолд 30 хоногийн дотор зөвшөөрөл олгоно:

4.2.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан шаардлагыг хангасан байх;

4.2.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хориглосон байршилд хамаарахгүй байх;

4.2.3. Хот төлөвлөлт, газар эзэмшил, шугам сүлжээ, улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хийх хот тохижилт, ногоон байгууламж, инженерийн хангамжийн бүтээн байгуулалт, засварын ажлуудтай уялдсан байх;

4.2.4. орон сууцны зориулалттай барилгын цонхгүй цул хана, дээвэрт сурталчилгааны байгууламж байрлуулах бол тухайн сурталчилгаа байрлуулах хэсэгт хамааралтай орон сууц өмчлөгчдийн дийлэнх олонхи зөвшөөрсөн нөхцөлд Сууц өмчлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн байх.

4.3. Гадна зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрлийг 1-3 хүртэлх жилээр олгох бөгөөд зөвшөөрөл олгосон иргэн, хуулийн этгээдтэй ажлын 5 хоногийн дотор 1 жилийн хугацаатай ашиглалтын гэрээ байгуулна.

4.4. Зөвшөөрөл авч, гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий байгууллагаар гадна зар сурталчилгааны байгууламжийн ажлын зургийг хийлгэж, барилга угсралтын тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгжээр сурталчилгааны байгууламжийг хийлгэж байрлуулна.

4.5. Гадна сурталчилгааны байгууламжийн эзэмшигч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөх бөгөөд гадна зар сурталчилгааны байгууламжийн ашиглалтын гэрээний хугацаа дуусгавар болохоос 30 хоногийн өмнө гэрээний хугацааг сунгуулах хүсэлт гаргана.

4.6. Гэрээний хугацааг сунгах эсэхийг гэрээний биелэлтийг дүгнэж, энэ журамд нийцүүлэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба шийдвэрлэнэ.

4.7. Гадна зар сурталчилгааны зөвшөөрлийг дараах тохиолдолд цуцална:

4.7.1. Ажлын зураггүй, барилга угсралтын зөвшөөрөлгүйгээр гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулах;

4.7.2. Гадна зар сурталчилгааны байгууламж өнгө үзэмж, аюулгүй байдлын хувьд тавих шаардлагыг хангахгүй бөгөөд зөрчлийг арилгах талаар энэ журмын 3.1-д заасан байгууллага болон мэргэжлийн улсын хяналтын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй;

4.7.3. Гадна зар сурталчилгааны байгууламжийн байршил хот тохижилт, бүтээн байгуулалтын ажлын талбайд орох болсон;

4.7.4.Иргэн, хуулийн этгээд нь төлбөрөө гэрээний дагуу төлөөгүй.

4.8.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн гадна зар сурталчилгааны байгууламжийн зөвшөөрлийг цуцлах шийдвэрийг энэ журмын 3.1-д заасан байгууллага гаргана.

4.9.Гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулах, ашиглах, хяналт тавихтай холбогдсон бусад харилцааг гэрээгээр зохицуулна.

#### **Тав. Гадна зар сурталчилгааг буулгах**

5.1.Гадна зар сурталчилгааны байгууламжийн эзэмшигч дараах тохиолдолд тухайн байгууламжийг өөрийн зардлаар буулгана:

5.1.1.Ажлын зураггүй, барилга угсралтын зөвшөөрөлгүйгээр гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулсан;

5.1.2.ашиглалтын гэрээний хугацаа дуусгавар болсон;

5.1.3.энэ журмын 4.7-д заасны дагуу зөвшөөрлийг цуцалсан.

5.2.Гадна зар сурталчилгааны байгууламжийг эзэмшигч нь энэ журмын 5.1-д заасан тохиолдолд түүнийг 10 хоногийн дотор өөрийн зардлаар буулгаж, орчны тохижилт, ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийг хийнэ.

5.3.Гадна зар сурталчилгааны байгууламжийг эзэмшигч нь энэ журмын 5.2-т заасныг зөрчсөн тохиолдолд албадан буулгах арга хэмжээ авч, холбогдох зардлыг түүгээр нөхөн төлүүлнэ.

#### **Зургаа. Гадна сурталчилгааны зөвлөл**

6.1.Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн дэргэд гадна зар сурталчилгаанд тавигдах шаардлага, байршил, тоо, хэмжээ, загвар, бүсчлэл, төлбөрийн зэрэглэл, хэтийн чиг хандлагыг тогтоох зөвлөмж боловсруулах үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл/цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана.

6.2.Зөвлөлийн дарга нь Улаанбаатар хотын Ерөнхий менежер байна.

6.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, ажиллах хуваарийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер батална.

6.4.Зөвлөл дараах байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ:

6.4.1.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба;

6.4.2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс;

6.4.3.Улаанбаатар хотын Цагдаагийн газар;

6.4.4.Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар;

6.4.5.Нийслэлийн Хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний газар;

6.4.6.Нийслэлийн Авто замын хөгжлийн газар;

6.4.7.Нийслэлийн Газрын алба;

6.4.8."Замын хөдөлгөөний удирдлагын төв" НӨҮГ;

6.4.9.Хот тохижилтын газар ОНӨААТҮГ;

6.4.10.төрийн бус байгууллагын төлөөлөл.

**Долоо. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба  
болон холбогдох бусад байгууллагын эрх, үүрэг**

7.1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба гадна зар сурталчилгааны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. гадна зар сурталчилгааны байгууламжийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

7.1.2. энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтарсан үзлэг, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгуулах;

7.1.3. энэ журмыг хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих зорилгоор гадна зар сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

7.1.4. зөвшөөрөлгүй болон энэ журмыг зөрчсөн гадна зар сурталчилгааны байгууламжийг буулгах арга хэмжээг зохион байгуулах;

7.1.5. согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн байгууламж энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавих;

7.1.6. Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулах зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдтэй ашиглалтын гэрээ байгуулж, төлбөрийг төсөвт төвлөрүүлэх;

7.1.7. хууль тогтоомжид заасан бусад.

7.2. Багануур, Налайх хотын Захирагчийн ажлын алба энэ журмын 7.1.2-7.1.5-д зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.2.1. дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулах зөвшөөрлийг энэ журмын 4.3-д заасны дагуу олгож, зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээдтэй ашиглалтын гэрээ байгуулж, төлбөрийг төсөвт төвлөрүүлэх;

7.2.2. энэ журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авсан арга хэмжээний талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд тогтоосон хугацаанд тайлагнах;

7.2.3. хууль тогтоомжид заасан бусад.

7.3. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.3.1. хаягийн байгууламжид тавих шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах;

7.3.2. аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хамтран ажиллах гэрээ байгуулахдаа хаягийн байгууламжид тавих шаардлагыг чанд мөрдүүлэх;

7.3.3. энэ журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авсан арга хэмжээний талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд тогтоосон хугацаанд тайлагнах;

7.3.4. нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, барилга байгууламж, эд хогшил, гэрэлтүүлгийн шон, хайс хашлага дээр нааж байрлуулсан зарлалын хуудсыг арилгуулах арга хэмжээ авах;

7.3.5. хууль тогтоомжид заасан бусад.

7.4. Нийслэлийн Засаг даргын дараах хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар гадны зар сурталчилгааны талаар доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.4.1. Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар нь шинээр барих барилга байгууламжийн зураг төслийг батлахдаа шаардлагатай хаягийн байгууламжийн орон зайг уялдуулан төлөвлөж, тусгуулах;

7.4.2. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, дүүргүүдийн Мэргэжлийн хяналтын хэлтэс нь нийслэлийн хэмжээнд байрлуулсан гадна зар сурталчилгаа, хаягийн байгууламжийн өнгө үзэмж, аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулан, хариуцлага тооцож ажиллах;

7.4.3. Нийслэлийн Газрын алба нь хувийн эзэмшлийн газарт гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд энэ журамд заасан шаардлагыг биелүүлэх тухай нөхцөл тусгаж, хэрэгжилтэд нь мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авах;

7.4.4. Нийслэлийн Авто замын хөгжлийн газар нь тухайн жилд хийх авто замын барилга, засвар, өргөтгөлийн ажлын төлөвлөгөөний талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг урьдчилсан мэдээллээр шуурхай хангаж ажиллах;

7.4.5. Нийслэлийн Эрүүл мэндийн газар нь эмнэлэг, эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоходо хаягийн байгууламжид тавих шаардлагыг хангуулах;

7.4.6. Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь зочид буудал, аялал жуулчлалын баазуудын хаягийн байгууламжид тавих шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэх;

7.4.7. Нийслэлийн Боловсролын газар нь төрийн өмчийн болон хувийн хэвшлийн бүх шатны сургууль, цэцэрлэг, боловсролын салбарын бусад байгууллагын хаягийн байгууламжид тавих шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэх;

7.4.8. Нийслэлийн Соёл, урлагийн газар нь театр, караоке гэх мэт урлаг, соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хаягийн байгууламжид тавих шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэх;

7.4.9. Улаанбаатар хотын Цагдаагийн газар нь Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд зохих журмын дагуу хариуцлага тооцож ажиллах;

7.4.10. Нийслэлийн Тээврийн газар нь нийтийн тээврийн хэрэгсэл /автобус, такси гэх мэт/-ийн гадаргууд байрлуулсан сурталчилгааны тавигдах шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэх.

7.5. Энэ журмын 7.4-т заасан байгууллага нь эрхэлсэн асуудлын хүрээнд авсан арга хэмжээний талаарх тайлан, мэдээг хагас жил тутамд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албандаа цахим хэлбэрээр хүргүүлж байна.

#### **Найм. Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг**

8.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь гадна зар сурталчилгааны байгууламжийн талаар дараах үүрэгтэй:

8.1.1. хууль тогтоомж болон энэ журмыг зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг бүрэн хариуцаж арилгах;

8.1.2. нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд гадна зар сурталчилгааны байгууламж байрлуулсан тохиолдолд дүйцэх төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;


8.1.3. зар сурталчилгааны тухай хууль тогтоомж болон энэ журмыг зөрчсөний улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг бүрэн хариуцаж арилгах;

8.1.4. нийслэл, дүүрэг, харьяа байгууллагуудаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, арга хэмжээг олон нийтэд сурталчлах зорилгоор сурталчилгааны байгууламжаа улирал бүр 10 хүртэлх хоногоор үнэ төлбөргүй ашиглуулах;

8.1.5. хууль тогтоомжид заасан бусад.

---ооо---

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 9/10  
дугаар тогтолцоны хөрдүгэаржансралт



**ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖ БАЙРЛУУЛАХЫГ  
ХОРИГЛОХ ГУДАМЖ, ЗАМ, ТАЛБАЙ**

1. Гадна зар сурталчилгааг доор дурдсан газруудад байрлуулахыг хориглоно:
  - 1.1. соёлын өвд бүртгэсэн хөшөө дурсгал, түүх, соёлын дурсгалт газар;
  - 1.2. музей, дархан цаазат газар;
  - 1.3. архитектурын өвөрмөц хийц бүхий барилга байгууламж;
  - 1.4. сүм, хийдийн барилга, түүний байнгын хашаа, хайс;
  - 1.5. төрийн байгууллага болон нутгийн захирагааны байгууллагын барилга байгууламж, түүний эзэмшлийн газарт.
2. Гадна сурталчилгааны тулгуурт болон гүүрэн байгууламжийг доор дурдсан гудамжинд байрлуулахыг хориглоно:
  - 2.1. Энхтайваны өргөн чөлөө /Саппарогоос Офицеруудын ордон/
  - 2.2. Чингисийн өргөн чөлөө;
  - 2.3. Сүхбаатарын гудамж;
  - 2.4. Их сургуулийн гудамж;
  - 2.5. Жуулчны гудамж;
  - 2.6. Олимпийн гудамж;
  - 2.7. Их Монгол улсын гудамж;
  - 2.8. Токиогийн гудамж;
  - 2.9. Бээжингийн гудамж;
  - 2.10. Сөүлийн гудамж;
  - 2.11. Бага тойруу болон түүнээс дотогш гудамж;
  - 2.12. Наадамчдын зам.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын  
2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 9/10  
дугаар тогтооны гуравдугаар хавсралт



## НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗАР, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД БАЙРЛУЛАХ ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖИЙН ТОЛБОР

1. Тулгуурт, дээврийн, гүүрэн, барилгын хана, хашаа, нийтийн тээврийн зогсоол дээр байрлах сурталчилгааны байгууламжийн 1 жилд ногдох төлбөрийн хэмжээг тооцоходоо  $1 \text{ m}^2$  талбайн үнийг нийт талбайгаар үржүүлж тооцно.

Талбайн хэмжээ $/\text{m}^2/$	1 $\text{m}^2$ талбайгаас авах хураамжийн хэмжээ гудамжны зэрэглэлээр / төгрөгөөр /		
	1-р зэрэглэл	2-р зэрэглэл	3-р зэрэглэл
1 $\text{m}^2$	160,000	80,000	40,000

2. Лед гэрлэн байгууламжийн 1 жилд төлөх төлбөрийн хэмжээг тооцоходоо нэг талын талбайн хэмжээгээр тодорхойлж талуудын тоогоор нэмэгдүүлж тооцно.

Талбайн хэмжээ $/\text{m}^2/$	1 $\text{m}^2$ талбайгаас авах хураамжийн хэмжээ гудамжны зэрэглэлээр / төгрөгөөр /					
	Дурс бичлэг гаргах зориулалттай			Текст гаргах зориулалттай.		
1-р зэрэглэл	2-р зэрэглэл	3-р зэрэглэл	1-р зэрэглэл	2-р зэрэглэл	3-р зэрэглэл	
1 $\text{m}^2$	140,000	70,000	30,000	70,000	45,000	20,000

3. Эзэлхүүн, орон зайд хамарсан зар сурталчилгааны байгууламж /Хоргот байгууламж, загварт байгууламж/-ийн төлбөрийг тодорхойлоходоо тухайн байгууламжийн эзэлхүүнээр тодорхойлно.

Эзэлхүүний хэмжээ $/\text{m}^3/$	1 $\text{m}^3$ эзэлхүүн бүхий байгууламжаас авах хураамжийн хэмжээ гудамжны зэрэглэлээр /төгрөг/		
	1-р зэрэглэл	2-р зэрэглэл	3-р зэрэглэл
1 $\text{m}^3$	40,000	20,000	10,000

4. Хөдөлгөөнт, нүхэн гарцын болон нийтийн тээврийн зогсоол дахь байгууламжийн төлбөрийг тодорхойлоходоо эзэлж байгаа талбайг тодорхойлон  $1 \text{ m}^2$  тутамд жил бүрийн 70'000 төгрөгөөр тооцно.

5. Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулсан хаягийн байгууламжийн төлбөрийг 1 дүгээр зэрэглэлд жилийн 300.000 төгрөг, 2 дугаар зэрэглэлд 200.000 төгрөг, 3-р зэрэглэлд 100.000 төгрөгөөр тооцно.

Нийслэлийн иргэдийн Төлөөлгөндын Хурлын  
2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 9/10  
дугаарт тогтолцын дөрөвдүгээр засвралт



## ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГААНД ТАВИХ ШААРДЛАГА

### Нэг. Сурталчилгааны байгууламж

1.1. Гадна зар сурталчилгааны төлөвлөлтийг зохион байгуулахдаа "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" баримт бичгийг мөрдөж, түүнтэй уялдуулна.

1.2. Гадна зар сурталчилгааны байгууламж нь гадна, эсхүл дотор гэрэлтүүлэгтэй байна.

1.3. Гадна зар сурталчилгааны байгууламжийг "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", "Цахилгаан техникийн угсралтын дүрэм", Барилгын норм, нормативын дагуу байрлуулж, ашиглалтад оруулна.

1.4. Гадна зар сурталчилгааны байгууламжийг байрлуулахдаа нэг орон зайд нэгэн жигд загвар, хэмжээтэй байх зарчмыг баримтална.

1.5. Гадна зар сурталчилгааны байгууламж нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхлахгүй байна.

1.6. Гадна зар сурталчилгааны байршил, хугацаа нь хот тохижилт, инженерийн хангамжийн байгууллагуудын бүтээн байгуулалт, засвар, үйлчилгээний ажлын график, төлөвлөгөөтэй нягт уялдсан байна.

1.7. Гадна зар сурталчилгааг дэд бүтцийн шугам сүлжээний хамгаалалтын зуравст байрлуулахгүй.

1.8. Гадна зар сурталчилгаа нь авто зам болон явган замын зорчих хөдөлгөөнд саад учруулахгүй байх бөгөөд замын байгууламжаас хэвтээ проекцоор 1 м зйтай байна.

1.9. Барилга байгууламжийн хана, дээвэрт байрлуулсан сурталчилгааны байгууламж нь тухайн барилгын аюулгүй, бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг алдагдуулахгүй байна.

1.10. Бусдын эзэмшил газар, барилга байгууламж, объектыг ашиглан нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайд гадна сурталчилгаа түгээх бол түүний эзэмшигчээс албан ёсоор зөвшилцсэн байна.

1.11. Гадна зар сурталчилгааны байгууламж дээрх сурталчилгааны бичвэр нь Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5-д заасны дагуу монгол /кирилл/ үсгээр алдаагүй бичигдсэн байх ба зохиогчийн эрхээр баталгаажсан бараа, бүтээгдэхүүний лого дээрх бичвэрт энэ нь хамаарахгүй.

1.12. Гадна зар сурталчилгааны байгууламжийн бүрэн бүтэн, өнгө үзэмжтэй, аюулгүй байдлыг хариуцах; урсгал засвар арчилгааг байнга хийж гүйцэтгэдэг байна.

1.13. Нийтийн тээврийн зогсоол дахь сурталчилгааны байгууламж дээр нийтийн тээврийн хэрэгслийн маршрут, мэдээллийг байрлуулсан байна.

## **Хоёр. Хаягийн байгууламж**

2.1. Гадна хаягийн байгууламжийн бичвэрийг Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалтын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд Монгол бичиг /уйгаржин/-ээр бичиж болно.

2.2. Шаардлагатай нөхцөл /бараа, бүтээгдэхүүний нэр, лого нь зохиогчийн эрхээр баталгаажсан, гадаадын иргэд олноор үйлчлүүлдэг/-д гадна хаяг, мэдээллийн байгууламжийн бичвэрийг англи хэлээр бичих бөгөөд бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх, эсхүл Монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.

2.3. Гадна хаягийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулах нөхцөлд дараах хэм хэмжээг баримтална:

2.3.1. автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчныг хязгаарлахгүй байх;

2.3.2. замын байгууламжаас 1 метрээс багагүй зайд байрлах;

2.3.3. авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй байх.

2.4. Барилгын хана, фасад дээвэрт байрлуулах гадна хаягийн байгууламж нь тухайн барилга болон хөрш зэргэлдээ объектын цонх, хаалга, үзэгдэх орчныг халхлахгүй байна.

2.5. Гадна хаягийн байгууламж нь гадна, эсхүл дотор гэрэлтүүлэгтэй байна.

2.6. Гадна хаягийн байгууламжийг байрлуулахдаа цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримталсан байна.

2.7. Барилгын даац, гадна фасадны бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байхын зэрэгцээ хууль ёсны эзэмшигч, ашиглагч нараас албан ёсоор зөвшөөрөл авсан байна.

2.8. Нэг барилга, объектод хэд хэдэн байгууллага, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тэдгээрийн гадна хаяг, мэдээллийн байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна:

2.8.1. нэг барилга байгууламжид байрлаж байгаа хэд хэдэн байгууллага, аж ахуйн нэгжийн гадна хаягийн байгууламжийн нийт овор хэмжээ нь жигд өндөрт байрлаж, ижил технологи материал ашиглан хийгдсэн байх бөгөөд өнгө, лого болон бичвэрийг тус туслын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн байрлуулах;

2.8.2. нийт хаягийн талбайн хэмжээ фасадны 20 хувиас хэтрэхгүй хэмжээтэй байх;

2.8.3. нэг барилгад үйл ажиллагаа явуулж байгаа хэд хэдэн байгууллагын гадна хаягийн байгууламжийг нийтийн эзэмшлийн талбайд байрлуулахаар бол бүх байгууллагын мэдээллийг агуулсан нэгдсэн хаягийн байгууламжийг тухайн барилгын эзэмшигч, өмчлөгчийн зүгээс байрлуулах;

2.8.4. аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэх үед мэдээллийг хялбар өөрчилж болох шийдэлтэй байх.


2.9. Гадна хаяг, мэдээллийн байгууламж нь хотын өнгө үзэмжид нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байх бөгөөд засвар, үйлчилгээг тогтмол хийж, бүрэн бүтэн байдлыг хангулна.

### Гурав. Хөдөлгөөнт гадна сурталчилгаа

3.1. Нийтийн тээврийн автобус болон троллейбусны гадаргууд сурталчилгаа байрлуулахдаа дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1. Тээврийн хэрэгслийн баруун талд зорчигчийн буух хаалганаас хойш, зурагт үзүүлсэн хэсэгт автобусны өндрийн 1/3 –ээс хэтрэхгүй өндөртэй байрлуулах /доорх зурагт харуулснаар/;

3.1.2. Тээврийн хэрэгслийн зүүн талд урд дугуйнаас хойш, гадаад гэрлэн хэрэгсэл, гараж дугаарыг халхлахгүй, автобусны өндрийн ½ –ээс хэтрэхгүй өндөртэй байрлуулах /доорх зурагт харуулснаар/;



3.2. Нийтийн тээврийн хэрэгслийн гадаргууд сурталчилгаа байрлуулахад дараах зүйлсийг хориглоно:

3.2.1. Сурталчилгаа байрлуулахдаа гэрэл буцаах нөлөөтэй хучилт, элементийг ашиглах, тээврийн хэрэгслийн үндсэн өнгийг алдагдуулах;

3.2.2. Гадаад гэрлэн хэрэгсэл, дугаар, мэдээллийн бичиг, тэмдгийг халхалсан сурталчилгаа байрлуулах;

3.2.3. Тусгай болон шуурхай албаны авто тээврийн хэрэгсэл дүрс, өнгө графикийн схемтэй төстэй реклам байрлуулах.